



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/24/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026-02-24 № 119

танай _____ ны № _____ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ГАНХӨЛӨГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 1 хөтөлбөр 7 арга хэмжээний хүрээнд нийт 1,164.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,103.7 сая төгрөгийг зарцуулж, 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай гэж үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь ОНХС болон бусад эх үүсвэрээс шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг орлого авсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6326050117

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	280,023,423.7	135,774,098.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,385,850,879.7	2,384,161,265.5
Нийт хөрөнгийн дүн	2,665,874,303.4	2,519,935,363.6
Нийт өр төлбөрийн дүн	-	11,375,484.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,665,874,303.4	2,508,559,879.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,665,874,303.4	2,519,935,363.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,776,447,756.9	1,466,789,276.5
Үйл ажиллагааны зардлын дүн	1,350,590,484.7	1,619,703,700.3
Үйл ажиллагааны үр дүн	425,857,272.2	(152,914,423.8)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	425,857,272.2	(152,914,423.8)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,240,017,031.3	2,661,474,303.4
Тайлант оны үр дүн	425,857,272.2	(152,914,423.8)
Эцсийн үлдэгдэл	2,665,874,303.4	2,508,559,879.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,147,801,246.4	1,207,232,666.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,132,192,246.4	1,152,137,466.0
Үйл ажиллагааны ЦМГ	15,609,000.0	55,095,200.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(15,609,000.0)	(55,095,200.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,103,684,262.3
Урсгал зардал	-	1,052,089,062.3
Хөрөнгийн зардал	-	51,595,200.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,103,684,262.3
Орон нутгийн төсвөөс	-	1,096,794,362.3
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	6,889,900.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 67.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын залрууллаа.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Залруулсан алдаа:

- ЗДТГ-ын 00-ын засварт 19.9 сая төгрөг, сантехникийн засварт 12.5 сая төгрөгийг зарцуулсан ч хөрөнгийг капиталжуулаагүй нь УСНББОУС-17, үнэлгээ ба хуваарилалт,
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 41 нэр төрлийн 192.8 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг 34.8 сая төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн нь УСНББОУС 17, тохиолдсон байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 38.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 1.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 36.7 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг хэмжээний 5.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14.5 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Төсвийн хөрөнгөөр 1.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл авч зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор орон нутгийн орлого болгох.

2. Хүний нөөцийн мэдээллийн системд нярвын үндсэн цалинг 7 дугаар сараас алдаатай оруулснаас нийт 0.4 сая төгрөгийн гарт олгох цалинг дутуу тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор орон нутгийн орлого болгох.

3.2 Албан шаардлага

1. Байгаль орчны байцаагчид гамшгаас хамгаалах асуудлыг хариуцуулан хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 30 хувиар тооцон 2025 онд 4.3 сая төгрөгийн цалин олгосон нь байгууллагын батлагдсан орон тоонд байхгүй ажлыг хавсран гүйцэтгүүлж нэмэгдэл цалин олгох шийдвэр гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль журмыг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны дотор биелэлт ирүүлэх

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Жилийн эцсийн тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, журмын дагуу тооллогыг үнэн зөв, чанартай явуулах, биелэлтийг 2026 оны 07 дугаар сарын 20-ны дотор биелэлт ирүүлэх

3. Засаг даргын тамгын газрын 00-ын засварын 19.9 сая төгрөг, сантехникийн засварын 12.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг цахимаар зарлаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана”, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг таслан зогсоож, холбогдох хуулийн дагуу худалдан авах ажиллагааг цахимаар зарлаж хэвшүүлэх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор биелэлт ирүүлэх

3.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 100 нэр төрлийн нийт 523.5 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй нь Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолтой нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ-ын засварт зарцуулсан ч хөрөнгийг капиталжуулаагүй	1	32,414.7	1	32,414.7			1	32,414.7				
Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн	1	34,782.8			1	34,782.8	1	34,782.8				
Дүн	2	67,197.5	1	32,414.7	1	34,782.8	2	67,197.5	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүний нөөцийн мэдээллийн системд нярвын үндсэн цалинг алдаатай оруулснаас гарт олгох цалинг дутуу тооцож олгосон	1	406.2	1	406.2								
Байгууллагын батлагдсан орон тоонд байхгүй ажлыг хавсран гүйцэтгүүлж нэмэгдэл цалин олгох шийдвэр гаргасан	1	4,324.4			1	4,324.4						
ЗДТГ-ын тооллогын комисс тооллого хийсэн ч тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй	1	-			1	-						
Дүн	3	4,730.6	1	406.2	0	-	0	-	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	0	-	0	-	0	-	0	-
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	1	1,066.3	1	1,066.3				
ЗДТГ-ын 00-ын засвар, сантехникийн засварыг худалдан авах ажиллагааг цахимаар зарлаагүй	1	32,414.7			1	32,414.7		
Дүн	2	33,481.0	1	1,066.3	1	32,414.7	0	-
Нийт дүн	2	33,481.0	1	1,066.3	1	32,414.7	0	-

-oOo-